Дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд тайлант хугацаанд дээд шатны төсвийн захирагчаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Физик, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хүрээлэн нь БШУС-ын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг”-ийг дагаж мөрддөг бөгөөд тус бодлогын баримт бичиг нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, хүрээлэнгийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус хүрээлэн нь 2024 оны 9 дүгээр сард Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад шилжиж ирсэнтэй холбоотойгоор салбарын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөх шаардлагатай гэж үзэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Физик, технологийн хүрээлэнгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,501,655.1 мянган төгрөг буюу 2.02 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	179,111.1	153,984.6	(25,126.5)
Бараа материал	118,681.9	116,864.5	(1,817.4)
Үндсэн хөрөнгө	4,295,031.1	4,230,805.9	(64,225.2)
Нийт хөрөнгө	4,592,824.1	4,501,655.1	(91,169.0)
Өглөг	43.0	74.0	31.0
Засгийн газрын хувь оролцоо	4,592,781.1	4,501,581.0	(91,200.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,592,824.1	4,501,655.1	(91,169.0)

Дараах дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 153,984.6 мянган төгрөгт хүрч, 25,126.5 мянган төгрөгөөр буурсан нь тайланд онд нэмэлт санхүүжилтээс зарцуулагдаагүй 128,672.4 мянган төгрөгийн авлагыг Сангийн яамтай тооцоо нийлж татаас санхүүжилтын авлагаар, 25,312.2 мянган төгрөгийг байгууллагаас авах авлагаар бүртгэсэн;
- Бараа материал дансны үлдэгдэл 116,864.5 мянган төгрөгт хүрч, 1,817.6 мянган төгрөгөөр буурсан нь 113,141.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 114,958.6 мянган төгрөгний бараа материал зарцуулсан байна;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,230,805.9 мянган төгрөгт хүрч, 64,225.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өөрийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгө 23,789.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2025 оны 10-р сарын 09-ны 482 тоот тогтоолоор үнэ төлбөргүйгээр хүлээн авсан үндсэн хөрөнгө 19,100.0 мянган төгрөг, дахин үнэлгээний нэмэгдлээр 179,740.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн. ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 26-ны 896 тоот тогтоолоор 276,935.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан, дахин үнэлгээний хорогдол 337,889.7 мянган төгрөгөөр, тайлант оны элэгдлийн зардал 286,855.1 мянган төгрөгөөр тус тус буурсанд;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,501,581.0 мянган төгрөгт хүрч, 91,200.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой;

Тус хүрээлэн нь 2022 оноос хойш Шинжлэх ухааны академийн санхүүгийн тайланд бүртгэлтэй Dynamic санхүүгийн программыг ашиглаж байна. Программ хангамжид ямар нэгэн төлбөр төлдөггүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Физик, технологийн хүрээлэнгийн 2025 оны төсвийн төсөлд санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 3,814,683.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 14,558.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 25,157.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 1,915.6 мянган төгрөг, нормативт зардлыг 4,500.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 16,647.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2,345.7 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 31,241.8 мянган төгрөг, нийт 96,366.9 мянган төгрөгөөр бууруулж 3,718,316.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсвийг 46,238.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 3,764,554.9 мянган төгрөгөөр тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 3,718,316.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, урсгал үйл ажиллагаанд 3,352,578.9 мянган төгрөгийг зарцуулж, 365,738.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,352,578.9 мянган төгрөг буюу 90.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 384,629.1 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын зардлыг 3,133.0 мянган төгрөгөөр, холбоо суваг ашигласны хөлсийг 6,780.1 мянган төгрөгөөр тус тус дутуу, ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшууллын зардыг 27,926.1 мянган төгрөг, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлыг 878.0 мянган төгрөгөөр тус тус илүү зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээний	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71805 Шинжлэх ухаан	3,718,316.9	3,352,578.9	365,738.0	90.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	3,623,624.1	3,238,995.0	384,629.1	89.4
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшуулал	39,728.4	67,654.5	(27,926.1)	170.3
80219 Харуул, хамгаалалтын зардал	41,345.1	38,212.1	3,133.0	92.4
80220 Холбооны суваг ашигласны хөлс	13,619.3	6,839.2	6,780.1	50.2
81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	-	878.0	(878.0)	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тайлант онд тус хүрээлэнгийн батлагдсан бүтэц, орон тоог 9 хувиар бууруулж цомхотгоогүй бөгөөд Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар орон тоог 118 байхаар баталж, гүйцэтгэлээр 107 орон тоотойгоор ажилласан байна.

Хүрээлэнгийн захирлын 2025 оны А/01 дугаар тушаалаар хоолны зардлыг ажлын нэг өдөрт 17.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 0.5 мянган төгрөгөөр тогтоосныг захирлын 2025 оны А/96 дугаар тушаалаар хоолны зардлыг ажлын нэг өдөрт 33.0 мянган төгрөг, унааны зардлыг 2.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна. Тайлант онд хоол, унааны хөнгөлөлтөд 468,742.2 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 294,904.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд дотоод томилолтын зардалд 14,278.7 мянган төгрөг, гадаад томилолтын зардалд 67,194.9 мянган төгрөг, нийт 81,473.6 мянган төгрөг, мөн 12 удаагийн хурал зөвлөгөөн зохион байгуулахад 28,789.8 мянган төгрөгийн тус тус зарцуулжээ.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 371,297.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 124,402.3 мянган төгрөг, нийт 495,699.8 мянган төгрөгийн орлого орж, 364,446.6 мянган төгрөгийг зарцуулан, зарцуулаагүй үлдэгдэл 131,253.2 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус хүрээлэн нь тайланд онд дараах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Тайлант онд зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Автомашин сэргээсэн батареийг цахилгаан нөөцлүүр болгон ашиглах боломжийг туршин тогтоох	2024-2025	Уг төслийн хүрээнд бид гибрид авто машины NiMH хаягдал батареийг сэргээн, багтаамжийг нэмэгдүүлэх, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх, физик химийн шинж чанрыг судлах	5,000.0	4,812.5
2	WQ3-оор хольцолсон никелийн хайлшуудын шүлтийн орчинд устөрөгч ялгарах процессын судалгаа	2023-2025	Төслийн хүрээнд үр дүнгийн даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэх; үр дүнгийн даалгавар нь никелийн буюу никелийн вольфрам оксидоор хольцолсон нэгдлийн каталитик идэвхийг харьцуулан судлахад чиглэгдсэн.	6,000.0	5,375.7
3	Шахагдсан устөрөгч дэх янз бүрийн давтамжтай хоёр лозерын цацрагын шугаман биш оптик хувиргалтаар спектрийн өргөн мужид орших когерент гэрлийг гарган авах	2023-2025	Шахагдсан устөрөгч доторх хоёр фотоны каскад ба дөрвөн фотоны параметр процессын онолын тооцоо, тоон загварыг боловсруулах	12,000.0	10,243.7
4	Хүний нүдэнд аюулгүй өндөр энергитэй гэрлийн параметрийн үүсгүүрийн судалгаа	2025-2027	Энэ төслийн зорилго нь нил улаан туяаны мужид хүний нүдэнд аюулгүй өндөр энергитэй цагираг хэлбэрийн резонартай гэрлийн параметрийн үүсгүүрийн зүй тогтолыг тогтооход оршино.	20,000.0	

**Физик, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

5	Металлографийн оптик микроскопын автоматжуулалт ба дижитал хөгжүүлэлт / ШУА гранд/	2025-2026	Системийн суурь эд ангиудын судалгаа, техникийн зураг төсөл боловсруулах нэг ажил	10,000.0	9,300.0
6	Нарны зайн бие даасан эх үүсгүүр бүхий фазын шилжилттэй материалтай дулаан хуримтлуурын судалгаа /ШУА гранд/	2025-2026	Цахилгаан эрчим хүчний бие даасан системийг фазын шилжилттэй материал бүхий дулааны хуримтлууртай хослон ажиллах туршилт хийх	10,000.0	10,000.0
7	Энергийн ялгарал ихтэй тогтмол соронз бүтээх наноматериалын дизайн болон шинж чанарын судалгаа АНУ, МУИС, ФТХ	2022.12-2025.09	Төмөр агуулсан нэгдлүүд (феррит, Ni Co агуулсан төмөрт хайлшууд), газрын ховор элемент агуулсан нэгдлүүдийн бүтцийг загварчлан тооцоолж, улмаар туршилгаар гарган авах боломжтой нэгдлийг тодорхойлох, туршилтаар тодорхой нэгдлийг гарган авах, тэдгээрийн соронзон болон бүтцийн судалгааг гүйцэтгэх	338,701.9	286,247.9

Хүний нүдэнд аюулгүй өндөр энергитэй гэрлийн параметрийн үүсгүүрийн судалгаа төслийн санхүүжилт тайлант оны 12 сард орж ирсэн тул зарцуулагдаагүй, Энергийн ялгарал ихтэй тогтмол соронз бүтээх наноматериалын дизайн болон шинж чанарын судалгаа төсөл нь 2025 оны 9 сард гэрээ дуусах байсан боловч санхүүжилт хойшилсонтой холбоотойгоор гэрээний хугацааг 6 сараар сунган үргэлжилж байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд багаж, техник хэрэгслийн зардалд 32,500.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Тайлант онд 75,804.5 мянган төгрөгийн 9 багаж худалдан авах төлөвлөгөө гаргаж баталснаас 3 багажийг 19,671.8 мянган төгрөгөөр худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Физик, технологийн хүрээлэнгийн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн хүрээлэнгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхөж дууссан үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь байршуулах, төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг хийж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Анализ старт аудит” ХХК-ийн ахлах аудитор Ц.Оюунтуул, аудитор Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Н.Энхтуяа, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор Ч.Мөнхбулган, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Физик, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 1/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,536,014.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 35,360.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус хүрээлэн нь 2025 онд нийт 12 удаагийн хурал, семинар, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 28,789.8 мянган төгрөг зарцуулсан бөгөөд дүгнэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллахдаа ихэнх хурал, зөвлөгөөн, семинарыг цахим хэлбэрээр зохион байгуулан ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-т заасан арга хэмжээ нь байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай шууд холбоотой бол хэмнэлтийн горимд хамааруулахгүй байж болно гэж заасныг үндэслэн үндсэн чиг үүрэгт хамааралтай эрдэм шинжилгээний хурал, семинарыг танхимаар зохион байгуулсан байна.

Физик, технологийн хүрээлэнгийн бүтцийн 6 нэгж албан бичгийн төсөл, цагийн бүртгэл, томилолтын удирдамж, чөлөөний хуудас зэргийг байгууллагын дотоод сүлжээ болон албаны цахим шууданг ашиглан төлөвлөдөг. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу захиргаанаас нэгдсэн журмаар албан бичиг, тушаал, шийдвэрийг гаргаж ажилладаг, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэж, нөөцлөөгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн байршуулбал зохих 171 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу 3.4.6 дугаар багажуудыг гадаад худалдан авалтаар нийт 19,671.8 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны тухай хууль болон ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Физик, технологийн хүрээлэнгийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, 309,230.3 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илрүүлж, 216,667.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн. Үүнээс завсрын аудитаар 92,563.0 мянган төгрөгийн 5 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 10,541.5 мянган төгрөгийн зөрчлөөс, 7,761.2 мянган төгрөгийн 2 хариуцлага тооцох албан шаардлага, 339.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,440.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	339.9	1	339.9	100.0
Хариуцлага тооцох албан шаардлага	2	7,761.2	2	7,761.2	100.0
Зөвлөмж	2	2,440.4	2	2,440.4	100.0
Нийт дүн	5	10,541.5	5	10,541.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан журмын дагуу бэлтгээд Finperform программ руу оруулахад санхүүгийн программаас хөрвүүлэлт хийгдэхгүй, гараар шивэлт үүсгэж оруулж байна. Мөн хоорондын тооцоо, төвлөрүүлсэн шилжүүлэгийн устгал хийгдэх процесс удаашралтай зэрэг хүндрэлүүд гарч байгааг сайжруулах шаардлагатай байна.

Харилцагч байгууллагуудтай өглөгийн үлдэгдлийг баталгаажуулж, тооцоо нийлсэн акт үйлдсэн боловч И-баримтын системд байгаа нэхэмжлэхийн дүн санхүүгийн байдлын тайлан дахь өглөгийн дүнтэй таарахгүй, өөрийн орлогод олгосон төлбөрийн баримтын дүнг дутуу шивсэн байгааг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,200.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилтийн 2 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулав. Үүнд:

- Хог хаягдлын хураамжийн төлбөрийг тооцооны данс дамжуулахгүй зардалд 360.0 мянган төгрөгийг шууд бүртгэсэн. Энэ нь УСНББОС-1, "Санхүүгийн тайлангийн толилуулга" санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна;
- Шатахууны төлбөрийг тооцооны данснаас бараа материалын данс дамжуулахгүй зардалд шууд бүртгэсэн. Энэ нь УСНББОС-1, "Санхүүгийн тайлангийн толилуулга" санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна;

Аудитаар нийт 232,016.4 мянган төгрөгийн зөрчил илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Аудитаар илрүүлсэн 232,016.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшинээс 196,656.3 мянган төгрөгөөр их байгаа боловч чанарын хувьд материаллаг биш гэж үзэн тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд 41 нэр төрлийн 45 ширхэг 216,667.2 мянган үнийн дүнтэй хөрөнгийг гадаад нэршлээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д *"Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нь нягтлан бодох бүртгэлээ монгол хэлээр хөтөлнө"* гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Монгол улсын хууль тогтоомжын дагуу монгол хэлээр бүртгэлийг залруулан бүртгэх;

Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 920,588.9 мянган төгрөгийн 257 нэр төрлийн үндсэн хөрөнгийг "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" журмын дагуу ТӨБЗГ-ын шийдвэр гаргуулаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын *"Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох"* журмын 7.1-д *"төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ"* гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээ нөхсөн 106 үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах талаар саналыг боловсруулж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын дансанд 188 нэр төрлийн тусгай зориулалтын материал, 3 нэр төрлийн сэлбэгийг гадаад нэршлээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д *"Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нь нягтлан бодох бүртгэлээ монгол хэлээр хөтөлнө"*, 20 дугаар зүйлийн 20.2.3-т *"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ*

хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын бүртгэлтэй гадаад нэршлээр бүртгэсэн хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомжын дагуу монгол хэлээр бүртгэлийг залруулан бүртгэх.

3. НБББББ-тай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус хүрээлэн нь 2024 оны 9 дүгээр сарыг хүртэл Хуучнаар БШУЯ-ны харьяанд байсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар БШУС-ын 2021 оны А/22 тоот тушаалаар батлагдсан НБББББ-ийг мөрдөж байна. ЗГ-ын шийдвэрээр 2024 оны 9 дүгээр сараас Эдийн Засгийн Хөгжлийн Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллаг болсон ба НБББББ-д өөрчлөлт оруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг; 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Стандарт, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан НБББББ-ийг төсвөөс зардал гаргахгүйгээр өөрчлөлт оруулан боловсруулах, багцлан бүртгэсэн номыг нэгжийн үнээр салгаж бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Физик, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хог хаягдлын хураамжийн төлбөрийг тооцооны данс дамжуулахгүй зардалд шууд бүртгэсэн байна	1	360.0			1	360.0	1	360.0				
Шатахууны төлбөрийг тооцооны данснаас бараа материалын данс дамжуулахгүй зардалд шууд бүртгэсэн байна..	1	4,840.0			1	4,840.0	1	4,840.0				
Дүн	2	5,200.0			2	5,200.0	2	5,200.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
41 нэр төрлийн 45 ширхэг Үндсэн хөрөнгийг гадаад нэршлээр бүртгэсэн байна.	1	216,667.2	-	-			1	216,667.2				

Физик, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

188 нэр төрлийн тусгай зориулалтын материал, 3 нэр төрлийн сэлбэгийг гадаад нэршлээр бүртгэсэн байна.	1	15,349.1					1	15,349.1			
Элэгдлээ нөхсөн 920,588.9 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 257 нэр төрлийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгуулаагүй байна.	1						1				
Хуучнаар БШУЯ-ны харьяанд байхад уг яамнаас гаргасан нэгдсэн НБББББ-ийг мөрдөж байсан ба энэ НБББББ-т "сургуулийн номын санд худалдаж авсан номыг "Номын фонд" гэсэн үндсэн хөрөнгийн дансанд анхны өртгөөр нь бүртгэнэ" гэснийг баримтлан номыг буруу ангилснаас гадна багцлан бүртгэсэн байна. 2024 оны 9 дүгээр сараас Эдийн засгийн Хөгжлийн Яаманд харьяалагдсан ба НБББББ-д өөрчлөлт оруулж мөрдөж ажиллаагүй байна.	1	-					1	-			
Дүн	4	232,016.4					4	232,016.4			